



# Христ өлссөн хүмүүсийг хооллосон

Нэг өдөр Есүс 5000 гаруй хүнд заасан юм. Орой болоход дагалдагчид нь хүмүүсийг гэртээ харьж хоол ундаа идэхийг хүсжээ. Есүс тэднийг явуулахыг хүссэнгүй. Тэр тэднийг хооллохыг хүссэн. Гэвч тэдэнд таван талх, хоёрхон загас байлаа.

Есүс хоолыг адислав. Дараа нь шавь нар нь хүмүүст тарааж өгчээ. Хүн бүрд хангалттай идэх хоол байв. Энэ бол гайхамшиг байлаа! ●

Та нар энэ түүхийг Матай 14:14-21-ээс уншиж болно.

## БИ ХУВААЛЦАЖ ЧАДНА

Хэнтэй хуваалцаж болох вэ?

---

Залбирч, тэдэнд туслах төлөвлөгөө гарга.

---

Төлөвлөгөөнийхөө дагуу үйлд!

---



**АНУ-ын Юта мужийн** хэсэг хөвгүүн орон гэргүй хүмүүст үйлчилдэг орон нутгийн буяны байгууллагад туслахаар оймс цуглуулах аян зохион байгуулжээ. Тараах материалыг тарааснаас хойш хэдэн

өдрийн дараа тэд оймс цуглуулж мөн нэмж олон оймс худалдан авах мөнгө цуглуулав. Тэд 750 хос оймс хандивлажээ.

Чи хэрхэн Есүстэй адил бусдад туслахыг хичээж байгаа вэ? Бидэнд хандан бичиж бас ярьж өгөөрэй.

---